



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: МУИС-ийн Дорнод дахь сургууль

Хөтөлбөрийн нэр: Боловсрол судлал магистр

Индекс: E011101

Шинжээчийн баг:

Ахлагч: Х. Алтанхундага / Ph.D/

Гишүүд: Н. Наранчимэг / Ph.D/

Б.Оюунцэцэг /Ph.D/

Улаанбаатар хот

2023 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга

Шалгуур 2: Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Шалгуур 3: Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт

Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

Товчилсон үгийн тайлбар

БСШУЯ- Боловсрол Соёл Шинжлэх ухааны яам

ДИС- Дорнод их сургууль

МУИС- Монгол улсын их сургууль

ШУТС- Шинжлэх Ухаан Технологийн сан

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	МУИС-ийн Дорнод аймаг дахь сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр	Боловсрол судлал магистрын хөтөлбөр Educational studies for master program	
Индекс	E011101	
Шинжээчид	Багийн ахлагч Х. Алтанхундага /Ph.D/ ОТИС-ийн Боловсрол судлалын тэнхимийн эрхлэгч Гишүүд: Н.Наранчимэг /Ph.D/ Удирдлагын академийн зөвлөх багш, проф Б. Оюунцэцэг / Ph.D/ МУБИС-ийн БС-ын сургуулийн зөвлөх багш	
БМИУЗ-ийн зохицуулагч	Магадлан итгэмжлэл харицсан шинжээч Б.Оюунчимэг	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2023.05.03	Шинжээчийн багтай гэрээ байгуулах
	2023.05.03	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хүлээн авах
	2023.05.08	Өөрийн үнэлгээний тайланг уншиж судлан дүгнэлт хийх, тодруулах асуудал бүхий урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид илгээх
	2023.05.19-20	Шинжээчийн баг сургууль дээр болон цахимаар ажиллах
	2023.05.29	Шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлт, тайланг илгээх.
Шалгуур шаардлага /журам/	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Сургуулийн танилцуулга:

Тус сургууль нь 1991 онд Багшийн сургууль нэртэйгээр байгуулагдаж,

- 1993 онд Дорнод аймаг дахь багшийн колледж;
- 2005 онд Дорнод дээд сургууль;
- 2015 онд Дорнод их сургууль;
- МУЗГ-ын 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн “Төрийн өмчийн зарим боловсролын сургалтын талаар авах арга хэмжээний тухай” 293 дугаар тогтоолын 3.1 дүгээр заалтаар Дорнод их сургуулийг Монгол Улсын Их Сургуулийн Удирдах зөвлөлийн хуралдааны 2022 оны 09 дүгээр сарын 8-ны өдрийн 05 дугаар тогтоолоор тус сургуулийг МУИС-ийн Дорнод аймаг дахь сургууль (МУИС, ДС) болгож өөрчилсөн.

Хөтөлбөрийн танилцуулга:

БСШУ-ны Сайдын 2015 оны 09 сарын 16-ны өдрийн А/202 тоот тушаалаар их сургуулийн ангилалд шилжин өргөжсөнөөр ахисан түвшний сургалт эрхлэх эрхтэй болж, магистрын түвшинд “Боловсрол судлал”-ын хөтөлбөрөөр сургалтыг зохион байгуулж ирсэн.

2015 оноос 11 удаагийн төгсөлт хийж, 271 магистрыг бэлтгэн гаргасан байна.

“Боловсрол судлал”-ын магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлж буй өөрийн үнэлгээний тайлант хугацаа нь 2018-2023 оныг хамарч байгаа бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилээс МУИС-ийн салбар сургууль болж, статус хэдий өөрчлөгдсөн ч Дорнод их сургуулийн тухайн үеийн байгууллагын нэршил, төлөвлөгөө, дүрэм журмыг энэхүү тайланд ашигласан болно. Мөн 2022-2023 оны хичээлийн жилийн илрэл нотолгоо, цаашид сайжруулж буй үйл ажиллагааг авч үзэхдээ МУИС-тай холбоотой дүрэм, журам, харьяаллын сургуультай холбоотой хүний нөөцийг ч мөн анхаарч авч үзсэн.

Магистрын хөтөлбөрийн зорилго:

- Боловсролын орчин үеийн онол, үзэл баримтлалыг ойлгон, нийгмийн хэрэгцээ, тулгамдаж буй асуудлыг мэдрэн, судлаачийн ёс зүйг эрхэмлэн, судалгаа, шинжилгээ хийж, үр дүнг баталгаа, нотолгоотой тайлагнах чадвар бүхий судлаач, мэргэжилтэн бэлтгэх

Хөтөлбөрийн төгсөгчийн загвар

1. Судлаачийн ёс зүйг эрхэмлэн дээдлэнэ.
2. Судалгаа хийх, үр дүнг тайлангнах, хэрэглэх чадвар эзэмшинэ.
3. Аливаа асуудалд шүүмжтэй хандаж, зөв өнцгөөс харах чадвартай болно.
4. Бусадтай харилцахдаа зөв боловсон харилцдаг, академик бичгийн өндөр чадвар эзэмшинэ.
5. Бусадтай багаар үр дүнэй ажиллах чадвар эзэмшинэ.
6. Тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголттой, өөрийн сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх чадвар эзэмшинэ.
7. Гадаад хэл тэр дундаа олон улсын хэл болох англи хэлийг судалгааны ажил хийхдээ хэрэглэх чадвартай болно.
8. Дижитал хэрэглээг судалгааны ажил хийхэд хэвшил болгоно.

Боловсрол судлалын магистрын төгсөгчид ба одоо суралцаж байгаа магистрантын тоо

БС-ын магистрын төгсөгчдийн тоо /сүүлийн 5 жил/	Суралцагчдын тоо	Багшлах бүрэлдэхүүний тоо
271	32	5

Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга

Дээд боловсролын болон сургуулийн зорилго, мэргэжлийн салбарын судалгаа ба хөгжлийн бодлоготой уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн боловсруулалт

Дээд боловсролын хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Магистрантын сургалт болон судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

- 2015, 2020, 2022 онд сургалтын төлөвлөгөөг боловсруулан *эрдмийн зөвлөлийн хурлаар 3 удаа хэлэлцүүлж* хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлаар тус бүр 2 удаа сайжруулж, *сургалтын төлөвлөгөөнд хичээл нэмэх, давхцыг арилгаж ирсэн.*
- Хөтөлбөрийн эрхэм зорилго, зорилтуудын хамаарлыг тодорхойлсон. /Тайлангийн хуудас 23/
- Олон улсын, үндэсний, орон нутгийн бодлогын баримт бичгүүдийг үндэслэл болгон боловсруулж, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан боловсролын бодлогыг дэмжин хэрэгжүүлж байгааг зурагласан. /Тайлангийн 14-17 хуудас /
- 2022 оны сургалтын төлөвлөгөө нь МУИС-ийн боловсрол судлалын магистрын сургалты төлөвлөгөөнд үндэслэн боловсруулагдсан. /Эрдмийн зөвлөлийн 2022.10.31 ны өдрийн хурлын тогтоол, сургалтын төлөвлөгөө/
- Олон улсын ижил төстэй 2 хөтөлбөр мөн МУБИС болон ОТИС-ийн хөтөлбөр, төлөвлөгөөг судалж харьцуулсан байна.

Онцлог зүйл /Туршлага:

- 2022-2023 оноос эхлэн МУИС-ийн салбар сургууль болж, тус сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй холбогдож ирсэн.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн ерөнхий хорооны 2016 оны 02 сарын 22 ны өдрийн хурлын тогтоолоор ахисан түвшний хөтөлбөрийн дэд хороог байгуулсан ч хөтөлбөрийн чанарыг сайжруулах үнэлэх чиглэлийн ажил хийгдээгүйг анхаарч ажиллах

- Хөтөлбөрт хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор хөтөлбөрийг боловсруулж, дүн шинжилгээ хийх

Зөвлөмж:

Хөтөлбөрийн чанарыг сайжруулах үнэлэх чиглэлийн ажлыг цаашид зохион байгуулж байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон глобал хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход хэрэглэгч ба оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Ахисан түвшний хөтөлбөрийн дэд хорооны хурлаар хөтөлбөрийн зорилгыг хэлэлцүүлж тодорхойлсон.
- Хөтөлбөрийн төгсөгчийн загварыг боловсруулахдаа 2019-2020 онд боловсрол судлалын магистрын хөтөлбөрт суралцагч 40, төгсөгч 54, профессор 10 багш, ажил олгогч 24 оролцогчоос судалгааг авч тусгасан.
- Хөтөлбөрийн төгсөгчийн загварыг 8 чиглэлийн хүрээнд боловсруулан хөтөлбөрийн хичээл бүрт хэрэгжүүлэхээр нарийвчлан тусгасан.
- Зүүн бүсийн аймгуудад чиглэгдсэн бодлого, алсын хараанд оруулах хувь нэмэрт хөтөлбөрийн оролцоог нэмэгдүүлэхээр их сургуулийн стратеги, төлөвлөгөөнд тусган /2023-2028 / ажиллаж байна.
- Орон нутгийн болон боловсрол, төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулж, хөтөлбөрийн чиглэлээрх судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудыг төлөвлөсөн.

Онцлог зүйл /Туршлага:

- Зүүн бүсийн аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт, хэрэгцээний талаар судалгаа, төслийг бичиж хөтөлбөрт тусган ажилласан.
- 2019-2020 онд боловсрол судлалын магистрын хөтөлбөрт суралцагч 40, төгсөгч 54, профессор 10 багш, ажил олгогч 24 оролцогчоос хөтөлбөртэй холбоотой судалгааг авч, үр дүнг тооцож, хөтөлбөр сайжруулахад анхаарч тусгасан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлт, төгсөгчдийн загварын талаар олон нийтэд мэдээлэх, танилцуулах ажил зохион байгуулж байх

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн загвар, хөтөлбөрийн өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлж, баримтжуулж байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3. Хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшний судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

Илрэл нотолгоо:

- 2015-2020 онд батлагдан хэрэгжиж ирсэн хөтөлбөрийн агуулгад давхардал үүсэж байсныг 2020 оны сургалтын төлөвлөгөөгөөр засан сайжруулсан.
- МУИС-ийн захирлын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/256 тоот тушаал “МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн журам” нийцүүлэн 2022 оны сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн агуулгыг боловсруулсан.
- Хөтөлбөрийн агуулгад мэргэшүүлэх хичээлд сонгон судлах 6 хичээлийг тусгасан.
- Судалгааны болон мэргэжлийн магистрын хөтөлбөрийн зорилго, агуулгыг ялгаатай байдлаар тодорхойлж, боловсруулан хэрэгжүүлж байна./Тайлангийн 26-28 хуудас/
- Зүүн бүсийн боловсролын байгууллагын багш, ажилтнуудын боловсролын түвшин, хөтөлбөрийн хүрээнд судлах хичээлийн агуулгын судалгааг хийж, “Судалгааны англи хэл”, “Боловсролын эрх зүй”, “Тэгш хамран сургах боловсрол” зэрэг хичээл судлах хэрэгцээг илрүүлж, тус хичээлийг боловсруулан хэрэгжүүлж ирсэн.
- Батлагдсан хичээлийн хөтөлбөрүүдтэй.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн Боловсрол судлалын тэнхим, багш нартай хамтран ажиллаж, хичээл заах багш нарын 60% -ийг тус сургуулийн багш нар зааж, хөтөлбөрийн заавал болон сонгон суралцах агуулгыг боловсруулж байна.

Анхаарах асуудал:

- Багш бус мэргэжлийн хүн тус хөтөлбөрт элсэн суралцахад мэргэжлийн бэлтгээ хөтөлбөр байхгүй байгааг анхаарах

Зөвлөмж:

- Багш бус мэргэжлийн хүн тус хөтөлбөрт элсэн суралцахад мэргэжлийн бэлтгэл хөтөлбөр байхгүй тул цаашид анхаарах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.4. Хичээлийн хөтөлбөрүүд

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэх ба тэдгээрийг суралцагчдад ил тод мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд гарын авлага болгон хэвлэсэн байна. Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн болон судалгааны магистрантын хичээлийн хөтөлбөрийг онцлогтой боловсруулсан.
- Нийт 15 хичээлийн хөтөлбөрийг бүрэн боловсруулсан нэг хичээлийн судлах багц цаг 3 кредит байна.
- Сонгон судлах хичээлд “Стратегийн хүний нөөцийн менежмент”, “Боловсролын инновц” зэрэг хичээлийг тусгаж, магистрантын хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн.
- Магистрантын үнэлгээнд бие даан ажиллах, мэдээлэл цуглуулж анализ хийх, Блуммын таксономийн хэрэглэх, үнэлэх, бүтээх түвшний хэлбэрийг түлхүү ашигладаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдэм шинжилгээ, судалгааны багц цагийн харьцааг тусгаж, магистрант бүр судлаач байхад анхаарч ирсэн.
- Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг олгож “Судалгааны англи хэл” хичээлийн хүрээнд ашиглах англи хэл дээрх 2017-2022 онд цахим орчинд нийтлэгдсэн 7 төрлийн 300 гаруй илтгэл, өгүүлэлийг татаж ашиглаж ирсэн.

Анхаарах асуудал:

- Хичээлийн хөтөлбөрүүд суралцагчдад ил тод мэдээлдэг байдал болон шаардлагатай тохиолдолд гарын авлага болгон хэвлэсэн болон цахимаар байхгүй тул гарын авлагатай болох
- Тухайн хичээлийн онцлогт тулгуурлан суралцахуйн зорилтот үр дүн, үнэлгээний аргачлал боловсруулах

Зөвлөмж:

- Магистрантад зориулсан гарын авлагатай болох

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**1.5. Хөтөлбөрт тавих тусгай шаардлага**

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байхаас гадна үндэсний болон олон улсын сайн туршлагыг нутагшуулахыг эрмэлзэнэ.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрийн хоорондын хамаарлын матрицийг суралцах улирал, курс, сонголтын багц бүрээр гаргасан. Ингэснээр улирал тус бүрд судлах хичээлийг хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн хоорондын хамааралтай холбосноор хөтөлбөр илүү бодитой хэрэгжих боломж бүрдсэн.
- Гадаадын их дээд, сургуулиудын хөтөлбөрөөс ижил төстэй хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Хонг Конгийн их сургууль, Кэмбрижийн их сургуулийг сонгон авч, хэрэгжүүлж буй хөтөлбөрт төгсөгчийн загвар, хичээлийн агуулгад тусгах боломжийг эрэлхийлэн ажилласан.
- Гадаадын 20 их дээд сургуультай хамтран ажиллаж, хөтөлбөрөө сайжруулсан ирсэн.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн ахисан түвшний хөтөлбөрт хэрэгжүүлж ирсэн сайн туршлагыг орон нутаг, харъяаллын сургуулийн онцлогт нийцүүлэн хөтөлбөрийг цаашид боловсруулахад анхаарч ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмжих үйл явцыг сайтар төлөвлөсөн байна.

2.1 Элсэлт

Элсэгчид тавих шаардлага нь магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOEFL, IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн талаарх сурталчилгаа, мэдээллийг олон нийтийн болон сургуулийн албан ёсны дижитал сувгуудаар дамжуулан, ил тод хүргэх бүхий л боломжийг нээлттэй явуулдаг байна.
- Элсэгчдэд тавих шаардлага хангасан, элсэгчдийг элсүүлэх, зохион байгуулах ажлын тушаал, шийдвэрүүд тогтмол гаргадаг. Тухайлбал:
 1. Судалгааны сэдвүүдийн жагсаалтыг АТС-ийн профессорын багаар хамтран ярилцаж, удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой байна.
 2. Монгол улсын БСШУ-ны сайдын 2007 оны 187-р тушаалаар батлагдсан “Магистр, Докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”
 3. Магистрант, докторын сургалт эрхлэх нийтлэг журам (БШУ-ны сайдын 2014.09.12 Захирлын А/370 тоот тушаал)
 4. МУИС-ийн Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам (2019.05.31 Захирлын А/249 тоот тушаал)
 5. МУИС-ийн магистрант, докторантын эрдэм шинжилгээ, дадлагын ажлын багц цаг тооцоход баримтлах түр журам (2016.05.04 Захирлын А/112 тоот тушаал)
 6. МУИС-ийн Сургалтын журам (2022.06.27 Захирлын А/256 тоот тушаал)
 7. МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журам (2022.05.08 Захирлын А/113 тоот тушаал)
 8. Гадаад, дотоодын их, дээд сургуулиас болон МУИС-ийн хөтөлбөр хооронд бүх түвшний суралцагч шилжүүлэн суралцуулах журам (2017.12.28 Захирлын А/256 тоот тушаал)
 9. Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь аймагт ажилласан элсэлтийн багийн тайлан “Магистрын элсэлтийн үйл ажиллагааны тайлан”, 2022.03.15
 10. <https://www.facebook.com/profile/100057719268588/search/?q=%D0%BC%D0%B0%D0%B3%D0%B8%D1%81%D1%82%D1%80>
 11. <https://dornod.edu.mn/magistrin-khotolbor-dawuu-tal>
 12. [蒙古语水平考试-1 2022-10-12 \(Сонсох, ярих, унших чадвар 1.5кр, \(office.com\)\)](#) Монгол хэлний түвшин тогтоох шалгалтын даалгавар, дүн

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн профессор багш нарыг дагалдан сургалт судалгааны ажлыг тасралтгүй тогтмол хөгжүүлж ирсэн.
- БНХАУ-ын мужуудаас элсэгчид олон элсэж, амжилттай төгссөн.
- Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмжих ажлыг зохих түвшинд тодорхой төлөвлөсөн.

Анхаарах асуудал:

- Дотоод, гадаадын элсэгчдийн үндсэн бакалаврын мэргэжлийг нягталж, магистрантурт элсүүлэх журмыг нарийн баримтлах

Зөвлөмж:

- Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзахаас гадна гадаад хэлний (TOEFL, IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээний журмыг нарийвчлан судлах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг

Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачаалал нь улирал бүрт жигд, зохистой хэрэгжиж хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг байна. Магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сүүлийн 5 жилийн сургалтын төлөвлөгөөндөө шинжилгээ хийж, засаж сайжруулж, хөгжүүлж иржээ. /Хавсралт-1/
- Магистрантын суралцах хугацаа хэвийн явагдаж ирсэн байна. /Хавсралт-2/
- Судалгааны болон мэргэжлийн магистрын түвшний “Боловсрол судлал”-ын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө
- Элсэлт, төгсөлтийн мэдээ, 2018-2022

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрантын суралцахуйн ачаалал, багц цагийг танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачааллыг тэнцвэржүүлэх, судалгаатай ажиллахыг хичээсэн сайн талтай
- Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг бүрэн хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Магистрантурын багшлахуй, суралцахуйн удирдлага мэдээллийн системийн цогцоор нь хөгжүүлэх

Зөвлөмж:

- Магистрантын суралцах хугацаанд, суралцагчдад зориулсан хөтөч гарын авлага, зөвлөмжийг онлайн болон хэвлэмэл хэлбэрээр хамтран хийж ном бүтээл гаргах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна. Үүний зэрэгцээ судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо

- Судалгааны ажлын жишиг төлөвлөгөө гаргасан.
- Судлаачийн ёс зүй, мэргэжлийн ёс зүйн сургалт, зөвлөгөө өгч ажилладаг.

Онцлог зүйл /Туршлага:

- Тайланд ”Суралцагч төвтэй сургалтын арга зүйг ашигладаг талаар ерөнхийд нь олон эх сурвалжаас эшлэл авч дэлгэрэнгүй бичсэн нь сайн талтай.
- Судалгааны магистрантууд жишиг төлөвлөгөө боловсруулж, удирдагч багштай хамтран хэрэгжүүлэхийг хичээж, суралцдаг туршлага байна.

Анхаарах асуудал:

- Багшлахуй, суралцахуйн чанар хөтөлбөрийг хэрэгжүүлэгч профессор багш бүрээс хамаарах тул “Хөтөлбөрийн иж бүрдэл”-ийг бүрэн хийж, хэрэгжүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- “Хөтөлбөрийн иж бүрдэл”-ийг хийж, хэрэгжүүлэх, сайн туршлагаас суралцаж, түгээн дэлгэрүүлэх

Шаардлага:

- Магистрантын сургалтын хөтөлбөрийг иж бүрдэлээр боловсруулж, хэрэгжүүлэхийн зэрэгцээ стандарт, хөтөлбөр, судалгааны ажлыг үнэлдэг шалгуур, үзүүлэлт, өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээг цаашид хийх тал дээр анхаарах

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.

2.4 Судалгааны ажил

Магистрант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Магистрант удирдах багш нарын тушаал шийдвэрүүдийг зохих журмын дагуу гаргаж ирсэн байна.

1. Монгол улсын БСШУЯ-ны сайдын 2007 оны 187-р тушаалаар батлагдсан “Магистр, Докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”
2. Дорнод их сургуулийн магистр, докторын сургалтын журам, 2015
3. ДИС-ийн Эрдэм шинжилгээ судалгааны ажилд тавигдах нийтлэг шаардлага, 2015
4. Магистрантын удирдагч багш томилсон тухай захирлын тушаалууд, 2018-2022 он

Онцлог зүйл/Туршлага:

Анхаарах асуудал:

- Судалгааны ажлын чанар, чансаа удирдагч багшийн ур чадвар, чадамжаас хамаарах талтайг анхаарч, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Магистрантын судалгааны ажлын ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөг магистрант бүрээр хийлгэж, АТС-ийн профессорын багаар хэлэлцүүлж, баталгаажуулдаг байх
- Магистрант бүрийн судалгааны ажлын гүйцэтгэлийг явцад нь тодорхой үе шаттай хэлэлцэж, дотоод, гадаадын олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж, өгүүлэл заавал нийтлүүлдэг байх ажлыг эрчимжүүлэх
- Магистрантын дипломын бичвэрүүдийн чанарт онцгой анхаарч, он цаг дарааллаар нь номын санд хэвлэмэл болон цахим хэлбэрээр байршуулах

Шаардлага:

- Судалгааны ажлыг Боловсрол судлалын мэргэжлийн профессор багш нарын баг удирдах, судалгааны ажлын чанарт анхаарах

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.

2.5. Бүтээлч ажил: Магистрант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцох, судалгааны бүтээлээ хэвлүүлдэг байна. Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.

Илрэл нотолгоо:

- Магистрант удирдах багш нарын тушаал шийдвэрүүдийг зохих журмын дагуу гаргаж ирсэн байна.

- ДИС-ийн эрдэм шинжилгээний бичгээр дамжуулан магистрантын судалгааны ажлыг танилцуулдаг байна.
- ДИС-ийн эрдэм шинжилгээний бичгээр дамжуулан магистрантын судалгааны ажлыг танилцуулдаг байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчиддөө ажлын байран дээрээ хөгжихөд дэмжлэг үзүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зөвлөн тусалж, сургуулийн болоод орон нутаг, улсын ЕБС, СӨБ-ийн сурган хүмүүжүүлэх уншлага, уралдаанд амжилттай оролцоход дэмжлэг үзүүлдэг туршлагатай.

Зөвлөмж:

- Магистрантын судалгааны ажлын ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөг магистрант бүрээр хийлгэж, ахисан түвшний профессорын багаар хэлэлцүүлж, баталгаажуулдаг байх
- Магистрант бүрийн судалгааны ажлын гүйцэтгэлийг явцад тодорхой үе шаттай хэлэлцэж, дотоод, гадаадын олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж, өгүүлэл заавал нийтлүүлдэг байх ажлыг эрчимжүүлэх
- Магистрантын дипломын бичвэрийн чанарт анхаарч, он цаг дарааллаар номын санд хэвлэмэл болон цахим хэлбэрээр байршуулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ БҮРЭН ХАНГАСАН.

Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулахад чиглэсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн явцад үнэлгээг гарцын 3 үнэлгээ, төрөл хэлбэрийг ашиглан суралцахуйн зорилтот үр дүнгийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой.

- МУИС-ийн захирлын 2022 оны 06 сарын 27-ны өдрийн А/25 тоот тушаал ”МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам”-д үнэлгээний журам шалгуурыг хэрэгжүүлдэг.
- Багшаас өгч буй даалгаврын холбоо хамаарал, оюутны гүйцэтгэж буй даалгаврын холбоо хамаарлыг тооцож, танин мэдэхүйн түвшинг харгалзсан.
- Сургалтын үнэлгээний систем МУИС-ийн SiSi систем ашиглаж эхэлж байна.
- Дорнод их сургуулийн эрдмийн зөвлөлийн 2015 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар Дорнод их сургуулийн магистр, докторын сургалтын журамд сургалтын үнэлгээг тусгасан.

Онцлог зүйл /Туршлага:

- Монголын их дээд сургуулийн 38 багш, 70 магистрантаас хөтөлбөрийн үнэлгээний даалгаврын төрөл, хэлбэрийг судлан илрүүлж, цаашид үнэлгээний даалгаврын сайжруулахад ашиглаж ирсэн.

Зөвлөмж:

- Хичээлийн онцлогт нийцүүлэн үнэлгээний журам, шалгуур ялгаатай байж болох боломжийг эрэлхийлэх
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт, голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт чанар, сурлагын ахицын талаарх статистик мэдээллийг тэнхмийн нийт оюутны тоогоор улирал бүр гаргадаг байх.
- Үнэлгээний шалгуурт оюутны бүтээлч үйл ажиллагаа, суралцах сэдэл, хандлагад чиглэсэн үйл ажиллагааг үнэлэх хэмжүүрээр хэмжихийг чухалчлах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.2. Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэхийг эрмэлзэнэ.

Илрэл нотолгоо:

- ДИС-ийн эрдмийн зөвлөлийн 2015 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар ”Дорнод их сургуулийн магистр, докторын сургалтын журам”-ын 8 дугаар зүйлд магистр, докторын шилжилт хөдөлгөөнийг тусгаж, баримталж ирсэн.
- Тухайн сургуульд суралцагч магистрант нь бусад сургуульд шилжин суралцах, өөр сургуулиас шилжин суралцах асуудал үүсэж байгаагүй.

- БСШУ-ны Сайдын 2021 оны 10 сарын 06 ны өдрийн А/348 “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”-д үндэслэн үнэлгээг тооцож ирсэн.

Онцлог зүйл /Туршлага:

- МУИС-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 02 ны өдрийн А/361 дугаар тушаал ”МУИС-д хичээл дүйцүүлэх журам”-д тодорхой заасан.

Анхаарах асуудал:

- БС-ын магистрантын хөтөлбөрөөр суралцагчдын голч дүнгийг судалгааг гаргаж тооцдог байх

Зөвлөмж:

- БС-ын магистрын хөтөлбөрт суралцагчдын голч дүнгийн судалгааг жил бүр гаргаж харьцуулалт хийж үзэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.3. Суралцагчийг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээтэй гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна. Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Гадаад оюутнуудын боловсрол судлалын магистрын хөтөлбөрт бэлтгэл хичээл 9 багц цаг хичээлийг нэмэлтээр судалдаг.
- ДИС-ийн оюутны хөгжлийн хөтөлбөрийг /2018-2022 он/ боловсруулан хэрэгжүүлж, дэмжих зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлж, үр дүнг тайланд тусгасан.
- ДИС-ийн дэргэдэх Дорнод Боловсролын мэдээллийн төвийн “Эрдэмтэнтэй ярилцах цаг”-ийг зохион байгуулж, 20 гаруй эрдэмтэн багштай уулзалт ярилцлагыг зохион байгуулж багш, магистрантуудыг оролцуулж ирсэн.
- БНХАУ-ын Хөлөнбуйр дээд сургуультай байгуулсан сургалт эрдэм шинжилгээ, инноваци болон ахисан түвшний сургалтын гэрээ байгуулж, хамтын ажиллагааг тооцож ирсэн.
- Магистрантын санал хүсэлт, гомдлыг ахисан түвшний хөтөлбөрийн албаны дарга хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг захиргааны зөвлөлийн хурлаар шийдвэрлэж,

албан тоотоор нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

Анхаарах асуудал:

- Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэж ирсэн дүрэм, журам байхгүй.

Зөвлөмж:

- Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч зөвхөн гадаадаас ирсэн тохиолдолд чиглүүлэгтэй хөтөлбөрт байгаа ч шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээтэй гэх мэт/ -ийг орхигдуулсан байгааг анхаарах

Шаардлага:

- Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тусгасан дүрэм, журмыг боловсруулах

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

3.4. Судалгааны санхүүжилт

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журмыг хэрэгжүүлж, жил бүр ил тод тайлагнадаг байна.

Илрэл нотолгоо:

- ДИС-ийн сургалт, судалгааны бодлого, хөтөлбөрийг эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлаж хэрэгжүүлж ирсэн.
- ДИС-ийн сургалтын бодлого төлөвлөлтийн албаны үйл ажиллагааны тайланд судалгааны бодлого хөтөлбөрийн явц, үр дүнг хянаж ирсэн.
- ДИС-ийн эрдэм шинжилгээний бүтээл нь /SBN978-99978-2-135-5/ судалгааны ажлыг дэмжих, санхүүжүүлэхэд чиглэгдэж ирсэн.
- Хамтран ажиллагч их сургуулиуд болон түншлэгч байгууллагууудын тусламжтайгаар судалгааны санхүүжилтийг нэмэгдүүлэх 4 төрлийн ажил зохион байгуулж ирсэн.
- Дээд боловсролын хүрээнд хамтран ажиллаж байгаа Erasmus төслийн хүрээнд судалгааны санхүүжүүлтийг нэмэгдүүлэн ажиллаж ирсэн.

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаадын 20 их, дээд сургуулиудтай хамтарсан гэрээтэй бөгөөд цаашид судалгаа хийх, эрдэм шинжилгээ судалгааны ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

- Зүүн бүсийн малчин залуучуудын боловсролд оруулах болон ажил мэргэжлийг нэмэгдүүлэх хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийх төслүүд бичигдэж байна.
- ШУТС-ийн захиалгат төслийн багт захирал, багш нар хамтран ажиллаж байна.

Зөвлөмж:

- ДИС-ийн судалгааны ажилд магистрантын оролцоог нэмэгдүүлэх
- Магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг үнэлэх боломжийг цаашид эрэлхийлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.5. Тэтгэлэг, тэтгэмж

Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журмыг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр хянан үнэлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ДИС-ийн эрдмийн зөвлөлийн 2021 оны 01 дугаар сарын 02 дугаар тогтоолоор ДИС-ийн магистрын судалгааны ажлын тэтгэлэг олгох журмыг боловсруулсан.
- “БНХАУ-аас Замын үүдэд суугаа Ерөнхий консулын газрын тэтгэлэг”-ээр 2020-2022 онд Боловсрол судлалын 20 магистрант нийт 8.155.000 төгрөг тэтгэлэг авсан.
- МУЗГ-ын 2018 оны 46 дугаар тогтоолын “Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам”-д заасны дагуу 2017-2022 онд нийтдээ 281 магистрантыг 298,344,750 төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Цаашид МУИС-д хэрэгжиж байгаа бүхий л тэтгэлэг, тэтгэмжийг магистрантуудад олгох асуудлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
- БНСУ-ын Боловсролын соёлын өдөрлөгийг зохион байгуулж, магистрантуудын тэтгэлэг тэтгэмжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.6. Судалгааны баг, хамтын ажиллагаа

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гадны судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- Гадаадын 20 их дээд сургуультай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй/ нотлох баримтаар жагсаалтыг гаргав. /
- ШУТС-ийн захиалгат төслийн багт болон орон нутгийн төрийн байгууллагын захиалгат төслийг хамтран гүйцэтгэж байна.
- Багш, магистрантууд хамтран гүйцэтгэсэн 1 судалгааны ажил байна.
- Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд АХБ-ны санхүүжилт, Боловсролын шинэчлэл төсөл, Швейцарын банкны хүн амын сангийн төсөл, Койка, Жайка, НҮБ-ын хүн амын хөгжлийн сан, БШУ-ын Сайдын багц зэрэг 14 төслийн хүрээнд судалгааны багт хамтран ажиллаж ирсэн.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС, ДС-ийн захирлын 2023 оны 04 сарын 03 ны өдрийн А/11 тоот тушаалаар судалгааны төсөл боловсруулах ажлын хэсэг томилж ажиллуулаж байна.
- Орон нутгийн онцлог аялал жуулчлал, боомт хотыг түшиглэн орон нутгийн төрийн захиргааны 4 байгууллагатай хамтран судалгаа хийж байна.
- Япон улсын ЛСА-ийн сайн дурын багш ажилуулж, цаашид судалгааны багаа өргөжүүлэхээр ажиллахаар төлөвлөж, албан бичиг хүсэлт илгээсэн, зөвшөөрөгдсөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.7. Магистрын ажил хамгаалалт

Магистрын ажил хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь магистрант, удирдагч нарт ойлгомжтой байна. Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.) магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

- ДИС-ийн захирлын тушаалаар магистрын ажил хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг жил бүр томилдог.
- Боловсрол судлалын магистрын хамгаалуулах зөвлөл 5 хүний бүрэлдэхүүнтэй, зохион байгуулах дүрэмтэй.
- Магистрантын судалгааны сэдэв нь Erasmus төслийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой тэгш хамруулах боловсрол болон ахисан түвшний хөтөлбөрийн албаны хурлаас батлагдсан, магистрант өөрөө сонгосон зэрэг байна.

Онцлог зүйл/Туршлага:

- 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн МУИС-ийн магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм хэрэгжиж эхэлж байна.

Анхаарах асуудал:

- Судалгааны магистрантуудын эрдэм шинжилгээний багц цагийг гүйцээсэн байдалд анхаарах

Зөвлөмж:

- Судалгааны магистрантуудын эрдэм шинжилгээний багц цагийн гүйцэтгэлд хяналт тавих

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.8. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн захирлын 2022 оны 06 сарын 27 ны А/256 тоот тушаалын хавсралт “МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам”-ийг хэрэгжүүлж байна.
- Төгсөгчдийн баримт бичиг олох үйл явцыг ДИС-ийн сургалтын үйл ажиллагааны журмын дагуу зохион байгуулж ирсэн. /Нотлох баримтаар төгсөлтийн баримт бичгийг хавсаргав/
- Төгсөлтийн бичиг, баримтын эх хувийг цахим хэлбэрээр шалгах боломжийг бүрдүүлэн ажиллаж, БШУЯ-ны мэдээллийн системд оруулан ажиллаж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- 2022-2023 оны хичээлийн жилийн өвлийн төгсөлтөөс эхлэн МУИС-ийн Дорнод их сургууль нэртэйгээр диплом, баримт бичгийн загварт өөрчлөлт оруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн

Магистрын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

4.1. Багшийн нөөц

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, докторантын тооны харьцааг зохистой

тогтоож, мөрддөг байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журмыг /А370/ үндэслэн магистрын сургалтыг доктор зэрэгтэй багш нар зохион байгуулж байна.
- МУИС-ийн захирлын 2015 оны 08 сарын 25-ны өдрийн А/234 тушаалын хавсралт “МУИС-д хүндэт, зөвлөх, гэрээт, зочин профессор, цагийн багш ажиллуулах журам”, 2019 оны 05 сарын 06-ны А/208 тушаалын хавсралт “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-ыг баримтлан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- БСШУ-ны Сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/270 тоот тушаал “Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага”-ыг батлах тухай тушаалын 2 дахь хэсэгт “Багшид тавигдах нийтлэг шаардлага”, 3 дахь хэсэг “Багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу багшид нийтлэг шаардлагыг тавьдаг.
- “ДИС болон МУИС-ийн профессор багш ажиллуулах журам”-ын дагуу багшийг ажиллуулдаг.
- Багшлах боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэхэдээ ИСА олон улсын байгууллагад албан бичиг илгээж багш ажиллуулахаар төлөвлөж, хамтран ажиллах зөвшөөрлийг авахаар болсон.

Онцлог зүйл/Туршлага:

- “Профессор багш ажиллуулах журам”-ын хүрээнд ажлын үр дүн ба урамшуулал, хариуцлагыг тооцож, ажилладаг байна.

Анхаарах асуудал:

- ДИС-ийн Судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг шинэчлэн боловсруулж, эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, мөрдөх

Зөвлөмж:

- Багш нарын эрдэмжилтэд анхаарч, зэрэг, цол ахиулах шуурхай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх
- Багш, докторантын тооны харьцааг нарийвчлан судалж, үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ, судалгааны баг бүрдүүлэх
- **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

4.2. Багшлахуйн үнэлгээ

Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга,

бодитой, системтэй, тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоо нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Дорнод их сургуулийн Эрдмийн зөвлөлийн 2016 оны 09 дүгээр сарын 22-ний өдрийн хурлаар “Дорнод их сургуульд багш ажиллуулах журам”-ыг хэлэлцэж баталж, багшийг үнэлэх үйл ажиллагаанд баримтлан ирсэн
- 2020 оноос эхлэн БСШУС-ын сайдын А/270 тушаал “Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага”-ыг мөрдлөг болгон багшийн албан тушаалын зэрэглэлийг ахиулах болон багшийн ажлыг уг шалгуур шаардлагын дагуу хагас жил болон жилийн эцэст үнэлгээ хийж байна.
- 2020 оны 12 сарын 24-ний өдрийн Эрдмийн зөвлөлийн хурлаар “Дорнод их сургуулийн профессор багшийн сургалт, эрдэм шинжилгээ, бүтээлч ажлын гүйцэтгэлийг тооцох журам”-ыг хэлэлцүүлэн баталж, багшийн А,Б,В цагийн нормт ажлыг үнэлсээр ирсэн.
- Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журмыг /А370/ үндэслэн магистрын сургалтыг доктор зэрэгтэй багш нар зохион байгуулж ажилладаг.
- 2022-2023 оны хичээлийн жилийн 2-р улирлаас “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-ыг баримтлан ажиллах зорилготой.

Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүр оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тооцон багшийн ажлыг үнэлдэг ба сургалтын үйл ажиллагааг сайжруулж ирсэн.
- Багшийн мэргэжлийн өсөлтийг дэмжих үүднээс судалгааны үр дүнг багшид танилцуулж үр дүнд суурилан багш өөрийн ур чадвар, хичээл зохион байгуулалтыг сайжруулан ажилладаг, туршлага хуримтлуулахыг хичээн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Үр дүнд суурилсан, үнэлгээний шинэ онол арга зүйд суралцах талаар анхаарах

Зөвлөмж:

- Ахисан түвшний профессор багш нарын судалгааны ажлын ахиц дэвшлийг үнэлэх шалгуур, үзүүлэлтийг боловсруулж, хэрэгжилтэд анхаарах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

4.3. Багшийн хөгжил

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инноваци нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Их сургуулийн хөгжлийн тулгуур-багшийн олон талт чадамжийг цогцоор нь хөгжүүлэх зорилго бүхий ДИС-ийн “Багшийн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг Эрдмийн зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн №06 тоот тогтоолоор баталгаажуулан ажиллаж байна.
- “Дорнод их сургуулийг хөгжүүлэх /2017-2024/ хөгжлийн төлөвлөгөө”-д багшийг хөгжүүлэх зорилгоор багшийн багшлахуй ба суралцахуйн чадамжийг хөгжүүлэх, судалгааны чадамжийг хөгжүүлэх, мэдлэг үйлдвэрлэл, инновацийн чадамжийг хөгжүүлэх цогц чадамжийг хөгжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулсан.
- “Багшийн хөгжлийн хөтөлбөр /2018-2022/”-ийг хэрэгжүүлж, багшийн олон талт чадамжийг цогцоор нь хөгжүүлэн улмаар сургалт, судалгааны чанарыг ахиулж, Дорнод их сургуулийн академик нэр хүндийг өсгөх тушаал шийдвэрүүд гарсан байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инноваци нэвтрүүлэх чиглэлээр гадаад эх сурвалж, ном бүтээлийг судалж, багшлахуйдаа тасралтгүй ашигладаг онцлогтой, дэмжин урамшуулдаг байна.

Анхаарах асуудал:

- Дижитал орчны сургалтын арга зүйн иж бүрдэл бүтээл хамтран хийхэд анхаарах

Зөвлөмж:

- Залуу багш нарыг идэвхижүүлэх зорилго бүхий хувь хүний хөгжлийн бодлогод анхаарч, багш нар шинэ арга зүй, инноваци нэвтрүүлэхэд хамтран суралцах
- Мэргэжлийн дотоод, гадаадын сургалт, семинарт багш нарыг өөрийн санаачлага болон сургуулийн зүгээс оролцуулах ажлыг эрчимжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.4. Судалгаа ба хөгжил

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- 2022-2023 оны хичээлийн жилээс МУИС-ийн захирлын 2012 оны 08 сарын 31-ний өдрийн 421 тушаалын хавсралт “МУИС-ийн оюуны өмчийн талаар баримтлах бодлого”, 2019 оны 05 сарын 06-ны өдрийн А/208 тушаалын хавсралт “МУИС-д профессор багш ажиллуулах журам”, 2022 оны 07 сарын 01-ний өдрийн А/270

тушаалын хавсралт “МУИС-ийн судалгааны санхүүжилтын журам”-ыг тус тусбаримтлан ажиллаж байна.

- Улирал бүр 2-аас дээш удаа ДИС-ийн болон гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдыг урьж “Эрдэм шинжилгээний их семинар”, “Эрдэмтэнтэй ярилцах цаг” нэвтрүүлэг хийгээд “Судлаачийн цаг” семинарыг зохион байгуулж, хэлэлцүүлэг өрнүүлдэг.
- 2023-2024 оны хичээлийн жилийн төсөвтөө Web of science-d бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэхэд профессор багш нарт дэмжлэг үзүүлэх, мөн англи хэлний хянан магадлагаанд зарцуулагдах зардал, ОУЭШ хурал 1 удаа зохион байгуулах зардал зэргийг суулгасан байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Нэг багш-нэг брэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг хичээсэн байна.
- Европын холбооны санхүүжилтээр Эрасмус төслийн хүрээнд Белгийн их сургууль, Польшийн Биалостикийн их сургууль, МУБИС, Ховд их сургуулиудтай хамтран “Монголд тэгш хамруулах боловсролын багш бэлтгэх” төсөлд хамрагдан магистрын “Боловсрол судлал” хөтөлбөрт “Тэгш хамруулах боловсрол” хичээлийг 3 кредитээр судлуулахаар оруулсан бөгөөд магистрантуудад төслийн тухай болон тэгш хамруулах боловсролын үзэл баримтлалын талаар сургалтууд зохион байгуулсан сайн тал ажиглагдлаа.

Анхаарах асуудал:

- Үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байх чиглэлээр сургуулийн зүгээс тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гадаад орны туршлагаас судалж, хамтран суралцаж, түгээн дэлгэрүүлэхэд анхаарах

Зөвлөмж

- Профессор багш нар магистрантуудыг судалгааны ажилд чадавхжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах

Шаардлага:

- Багшийн хөдөлмөрийн үнэлгээг /үндсэн цалин, цагийн хөлс/ өсгөх
- Багшийн эрдэм шинжилгээ, судалгаанд хэрэглэгдэх олон улсын чансаатай эрдэм шинжилгээний сэтгүүлийн өгүүллийн нөөцийг өсгөх

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт

Суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх, судалгааны ажлыг чанартай хийхэд шаардагдах нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн байнгын хөгжлийг дэмжих санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байна.

5.1. Сургалт, судалгааны орчин

Тухайн хөтөлбөр, шинжлэх ухааны чиглэлээр магистрант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлж, багш, суралцагчдын сэтгэл ханамжид үндэслэн сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын сургалтын байгууллагад тавигддаг нийтлэг шаардлагыг хангасан зориулалтын барилга байгууламж, дотуур байртай /гэрчилгээ, хичээлийн байрны талбайн хэмжээ 6825м², дотуур байрны талбайн хэмжээ 1 дүгээр байр-825.6м², 2 дугаар байр-923.6м²/
- Лекцийн, семинарын, лингафоны, компьютерийн болон оюутны бие даан суралцахыг дэмжих төвийн 1 оюутанд ногдох талбай боломжийн /нэг оюутанд лекцийн-0.9, семинарын-1.6, лингафоны-2.7, компьютерийн-3.1 м²/
- Хэрэгцээтэй тоног төхөөрөмж, гол программ хангамжийг бүрдүүлсэн /тоног төхөөрөмжийн судалгааг хүчин чадал, ашиглалтад орсон хугацаа, хаана байрлуулсан зэргээр шинэчлүүлж хийлгэсэн/
- Багш, оюутанд багшлахуй, суралцахуйн цахим орчин бүрдүүлэхэд анхаарч шаардлагатай тоног төхөөрөмж /тодорхой болгох үүднээс 2022.01.01-2023.01.05 хугацаанд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн судалгааг нэмж хийлгэсэн, 114.471.740₮/, программ хангамжаар хангасан /2020-2021 хичээлийн жилээс Microsoft office 365 платформ, 2022-2023 оны хичээлийн жилээс МУИС-ийн программ хангамжтай холбоотой болж байна/

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын зориулалттай спорт, урлагийн заал, анги танхим нь хангалттай түвшний хичээлийн байртай
- Ахисан түвшний сургалтын суралцагчдад хичээллэх болон бие даан суралцахад нь зориулж тусгайлсан танхим тохижуулсан /№207 танхим-магистрантын бие даан суралцах төв, №214 танхим-оюутны суралцахуйг дэмжих төв, №121 танхим-хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв гэх мэт/
- Багш нарт шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжаар хангахад тусгайлан анхаарсны дүнд урьд өмнө хийгдэж байгаагүй хөрөнгө оруулалтыг сүүлийн 5 жилд хийсэн.

Анхаарах асуудал:

- Хичээлийн болон дотуур байранд капитал засвар хийх

- Сургалтын тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа уртгассан байна.
- Сургуулийн гадаад, дотоод орчны тохижилт, сайжруулалт дутмаг

Зөвлөмж:

- Мультимедиа студийг шинэчилж, нийт программ хангамжуудаа МУИС-тай нийцүүлэн “цахим” сургалтын хүрсэн түвшинг бууруулалгүй, бүх хичээлийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн “зайн” хэлбэрт бүрэн шилжүүлэхэд ашиглах, сургалтын тоног төхөөрөмжүүдийг тусгайлсан төлөвлөгөөний дагуу үе шаттай, шуурхай шинэчлэх
- Хичээлийн болон дотуур байранд капитал засварыг хийх боломжийг судлах, эсвэл жил бүрийн урсгал засварт зарцуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжуудыг судалж ашиглах
- Гадаад орчиндоо суралцагчид, багш, ажилтнуудын дунд аян өрнүүлэх зэргээр ногоон орчин бүрдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.2. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг хангалттай бүрдүүлж, судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг багш, магистрантууд хэвлэмэл болон цахим хэлбэрээр нээлттэй ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- 25000 гаруй номтой номын фонд, “чимээгүй” болон “эрдэм шинжилгээний” уншлагын танхимуудтай, Lib4U улмаар МУИС-ийн номын санг ашиглах боломжийг нээж байна /тухайн хөтөлбөрийн 15 хичээлд хэрэгцээтэй үндсэн 66 төрлийн сурах бичиг, гарын авлага нь 646 ширхэг байна, судалгааг хавсаргав/
- Хятад улсын CNKI номын, төлбөртэй, цахим санд нэвтрэх боломж бүрдүүлж байгаа
- Олон улсын нээлттэй гол эх сурвалжуудад нэвтрэх боломжийг суралцагчид ашиглаж байна /жагсаалт нь тайлангийн хуудас 110/

Онцлог зүйл /Туршлага:

- Боловсрол судлалын хичээлүүдтэй холбоотой 300 гаруй өгүүллийг гадаад эх сурвалжаас татан магистрантуудад ашиглахад нь хялбар болгосон.

Анхаарах асуудал:

- Сургалтын хөтөлбөртэй холбоотой сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүний нийлүүлэлт буурсан.
- ДИС-ийн багш нарын боловсруулсан сурах бичиг, гарын авлага, хэрэглэгдэхүүн дутмаг.

Зөвлөмж:

- Сүүлийн жилүүдэд шинэ ном, хэрэглэгдэхүүний нийлүүлэлт буурсанд анхаарч хандив, тусламж, худалдан авалтыг бодлогоор дэмжих

- Багш нарыг сургалт, судалгааны хэрэглэгдэхүүн /тестийн сан, дасгалын хураамж, даалгаврын дэвтэр, унших материалын эмхтгэл, хичээлийн агуулгын зурган танилцуулга зэргээс эхлэн/, гарын авлага, улмаар сурах бичиг боловсруулахыг дэмжихдээ олгогддог цагийн хэмжээг нэмэгдүүлэх, хэвлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шагнал, урамшуулал олгох, уралдаан зохион байгуулах, алдаршуулах, бүтээлийн үзэсгэлэнг тогтмолжуулах зэрэг тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/

5.3. Төсөв, санхүүжилт

Хөтөлбөр олон эх үүсвэрээс санхүүжих ба хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөвтэй байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багшлахуй, суралцахуйн хөгжилд зарцуулдаг, үүнд багш нарын саналыг харгалздаг байна.

Илрэл нотолгоо:

- Нийт төсвийн гол хувийг боловсрол судлалын ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн төлбөр бүрдүүлдэг /төсвийн бүрдүүлэлт/
- Тухайн хөтөлбөрийн санхүүжилтийн дийлэнх хувийг багшлахуй, суралцахуйд зарцуулдаг /Мөнгөн гүйлгээний дэлгэрэнгүй журнал/

Онцлог зүйл /Туршлага:

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, шинэчлэхэд тухайн хөтөлбөрийн санхүүжилтийн орлого нь үндсэн үйл ажиллагаандаа бүрэн зарцуулагддаг /багшийн цалин, сургалт, судалгааны ажил, хөтөлбөрийн хяналт үнэлгээ, шинэчлэл, суралцагчдын дунд зохион байгуулж байгаа үйл ажиллагаа зэрэгт/ нь нэг талаас сайн мэт ч нөгөө талаас байгууллагадаа үр ашиггүй байх талтай

Анхаарах асуудал:

- Сургалтын төлбөрөөс бусад санхүүжилтийн эх үүсвэр дутмаг
- Элсэгчдийн тоо буурсан

Зөвлөмж:

- Санхүүжилтийг нэмэгдүүлэхэд орон нутгийн боломжийг ашиглах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад болон дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, багш, хамт олон, суралцагчдын хүчийг нэгтгэн зохион байгуулалтад оруулан тэдгээр байгууллагуудад хэрэгцээтэй үйчилгээний төрөл, хэлбэрүүдийг өргөжүүлэн үзүүлж харилцан хамтын ажиллагаанд суурилах
- Дотоод болон гадаадын элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, үүний тулд сургалтын хөтөлбөрийн танилцуулга, сурталчилгааг бүсийн болон үндэсний түвшинд сайжруулах, элсэгчдийг татах содон бодлого баримтлах
- Сүүлийн жилүүдэд шинэ ном, хэрэглэгдэхүүний нийлүүлэлт буурсанд анхаарч хандив, тусламж, худалдан авалтыг бодлогоор дэмжих

Шаардлага:

- Санхүүжилтийн талаар цаашид баримтлах бодлого боловсруулж, төлөвлөлт хийн хэрэгжүүлэх
- Багш нарыг сургалт, судалгааны хэрэглэгдэхүүн /тестийн сан, дасгалын хураамж, даалгаврын дэвтэр, унших материалын эмхтгэл, хичээлийн агуулгын зурган танилцуулга зэргээс эхлэн/, гарын авлага, улмаар сурах бичиг боловсруулахыг дэмжихдээ олгогддог цагийн хэмжээг нэмэгдүүлэх, хэвлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шагнал, урамшуулал олгох, уралдаан зохион байгуулах, алдаршуулах, бүтээлийн үзэсгэлэнг тогтмолжуулах зэрэг тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлэх
-

Шалгуурыг хангасан байдал: /Хэсэгчлэн хангасан/

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд нийцсэн засаглал ба удирдлагын тогтолцоотой, захиргааны зохистой бүтэц, удирдлагын мэдээллийн системтэй байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэцтэй байх ба академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг нь сургалтад оролцогч талуудтай, тухайлбал, ажил олгогчид, төгсөгчид, нутгийн удирдлагын байгууллагуудтай байнгын мэдээлэл солилцох, хамтран ажиллах, ОХУ болон БНХАУ-тай хил залгаа тул сургалт, судалгааны байгууллагуудтай нь хамтын ажиллагаатай байх зэрэг давуу талтай /санамж бичиг, гэрээ, гүйцэтгэлийн тайлан/
- Сургуулийн бүтэц сүүлийн 5 жилд 2 удаа өөрчлөгдсөн, 2023 оноос МУИС-ийн салбар сургууль болсонтой холбоотой бүтэц дахин өөрчлөгдөж байгаа ч засаглал, удирдлагын хувьд олон давуу талууд бий болж байна /Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрүүд/
- Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын тогтолцоог МУИС-ийн зохицуулалтад үндэслэсэн, цалинг нэмэгдүүлсэн /захиргааны зөвлөлийн шийдвэрүүд/

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн удирдлагын бодлого болон үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад Дорнод салбар сургууль өөрийн бодлого, эрх зүйн орчноо нийцүүлэн зохион байгуулж байгаа нь цаашдаа удирдлагын бодлого нь тогтвортой, оновчтой байх нөхцөлийг бүрдүүлж байна

Анхаарах асуудал:

- Сургууль хөгжүүлэх удирдлагын бодлого, төлөвлөлт шинэчлэгдэн боловсруулагдах эхний шатанд байгаа
- Багш, суралцагчдын засаглалын үйл ажиллагаан дахь оролцоо сул

Зөвлөмж:

- МУИС-ийн харьяалалд шилжиж байгаатай холбоотой сургуулийн удирдлагын бүтэц, удирдах ажилтнууд өөрчлөгдсөн тул сургууль хөгжүүлэх стратегийн бодлогыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх
- Шинэчлэгдэж байгаа бодлогын болон эрх зүйн баримт бичгүүдэд засаглалын гол зарчмууд болох үр дүн, өгөөж, оролцоо, ил тод байдал, хариуцлага, тэгш байдал зэргийг оночтой тусган хэрэгжүүлэх
- Удирдлагаас төлөвлөлт, төсөвлөлт, хяналт шинжилгээ, гүйцэтгэлийг тооцох байдал зэргээ эргэн хянаж оновчлох

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.2. Ажилтнууд

Захиргааны болон туслах ажилтны орон тоо хангалттай, зохих ур чадвар, туршлагатай байна. Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь дэмжлэг үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Захиргааны болон туслах ажилтны орон тоонд зохих ур чадвар, туршлагатай 20 ажилтантай

Анхаарах асуудал:

- Бүртгэл, мэдээллийн системийн ажилтан дутагдалтай
- Ажилтнуудын шилжилт хөдөлгөөн буураагүй

Зөвлөмж:

- Ажилтнууд төдийгүй багш нарын шилжилт хөдөлгөөн энэ 5 жилийн хугацаанд багасаагүй байгааг тооцож, / 1/цалин хөлс бага, 2/хүний нөөц орон нутагт хомс байдаг, 3/ковид зэрэг урьдчилан тооцоогүй нөхцөл байдал үүссэн зэрэг сургуулийн бодлого, үйл ажиллагаанаас төдийлөн хамаараагүй хүчин зүйлүүд нөлөөлсөнтэй холбоотой/ цаашид хүний нөөцийн бүрдүүлэлтэд анхаарах
- Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх

Шаардлага: Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3. Удирдлагын мэдээллийн систем

Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй байна. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Cloud University мэдээллийн системийг ашигладаг
- 2022-2023 хичээлийн жилээс Sisi системийг ашиглаж эхэлж байна

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-д дээрх системүүдийг ашигладаг болсон нь зөвхөн уг сургуулийн төдийгүй нийт сургуулиудын мэдээлэл солилцох, нэгдсэн удирдлагаар хангах боломжийг бий болгож байна.

Анхаарах асуудал:

- Сургуулийн шаардлагатай мэдээллийн баазыг бүрдүүлж дуусаагүй
- Системын ашиглалт бүрэн биш

Зөвлөмж:

- МУИС-ийн Sisi системийн ашиглалт эхэлж байгаа тул мэдээллийн баазыг шуурхай бүрдүүлж, ашиглалтын хүрээг өргөжүүлэх
- Удирдлагын мэдээллийн системийг МУИС-ийн жишигт бүрдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан/**6.4. Мэдээллийн ил тод байдал**

Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой үнэн зөв мэдээллийг багш, суралцагчдад нээлттэй хүргэж, цаашид тогтмол шинэчилдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хөтөлбөрийн онцлог, танилцуулга, элсэгчдэд тавигдах шаардлага, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд, үнэлгээний аргачлал зэрэг нь суралцагчдад болон элсэхийг сонирхогчдод нээлттэй /сургуулийн сайт болон бусад хэрэгслээс ил тод байна/

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагч, багш нарын тоо цөөн, орон нутагт, мөн тодорхой үйл ажиллагаа эрхэлдэг цомхон байгууллага тул мэдээллийн солилцоо, урсгал сайн

Анхаарах асуудал:

- Гадагшаа чиглэсэн хөтөлбөрийн сурталчилгааны үр өгөөж сул

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрийг сурталчилгааны олон арга, хэлбэрүүд, эх сурвалжуудыг ашиглан бусад аймгуудад болон ОХУ, БНХАУ-д эрчимжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.

7.1. Дотоод чанарын баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт ба төгсөлт, төгсөгчдийн ажил эрхлэлт гэх мэт) тус бүрийг байнга, тогтмол давтамжтайгаар хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талууд оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- Чанарын дотоод баталгаажуулалтын төлөвлөгөө, хэрэгжсэн ажлын үр дүнг тооцсон тайлантай.
- ДИС нь “Сургалтын хөтөлбөрийн хөгжил, чанарын баталгаажуулалт 2018-2022 хөтөлбөрийг хэрэгжүүлж 4 зорилтын хүрээнд ажиллаж ирсэн.
- ДИС нь хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хяналт үнэлгээ, шинжилгээний мэргэжилтэн болон хөтөлбөрийн хороо хагас жил тутам үнэлж хянаж ирсэн.

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг тогтолмжуулсан.

Анхаарах асуудал:

- Магистрын хөтөлбөрийн чанарын үнэлгээг зохион байгуулах

Зөвлөмж:

- Магистрын хөтөлбөрийн чанарын үнэлгээг тогтмолжуулж байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.2. Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл

Жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Магистрын түвшний хөтөлбөрийг сайжруулах төлөвлөгөөг/ 2022-2026 онд/ боловсруулж өөрийн үнэлгээ хийж ирсэн.
- БМИҮЗ-ийн зохицуулагчдаас жил бүр хөтөлбөр сайжруулах, хэрэгжүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөөг авч ирсэн.
- Боловсрол судлалын магистрын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын матриц зураглал хийсэн.
- Үр дүнд суурилсан сургалтын арга зүйгээр соёл судлал хөтөлбөрийг шинэчлэх ажлыг эхлүүлсэн байна. Ажлын төлөвлөгөөтэй танилцсан.

Зөвлөмж:

Дотоод чанарын хяналт үнэлгээний алба эсвэл нэгжтэй болох

Шаардлага:

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан:

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга	1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5			
2	Магистрын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	2.1,2.2 2.5	2.3, 2.4		
3	Магистрантын суралцахүйн үнэлгээ,	3.1,3.2,3.4, 3.5,3.6, 3.7	3.3,		
4	Багшлах бүрэлдэхүүн	4.1, 4.2, 4.3	4.4		
5	Нөөц ба санхүүжилт	5.1 ,5.2	5.3		
6	Удирдлага ба мэдээллийн систем	6.1, 6.2, .6.3, 6.4			
7	Чанарын баталгаажуулалт	7.1, 7.2			

Дүгнэлт	Бүрэн хангасан
---------	----------------

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУИС, ДИС, Боловсрол судлалын магистрын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН/ гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Боловсрол судлалын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэгХ. Алтанхундага / Ph.D/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....С. Наранчимэг /Ph.D/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Б. Оюунцэцэг / Ph.D/

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга	Хөтөлбөрийн чанарыг сайжруулах үнэлэх чиглэлийн ажлыг цаашид зохион байгуулж байх
Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	Элсэгчидээс гадаад хэлний (TOEFL, IELTS) шалгалтыг зохион байгуулах журмыг нарийвчлан судлах
Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил	<ul style="list-style-type: none"> Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журмыг боловсруулж, хэрэгжүүлэх
Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> Залуу багш нарыг идэвхижүүлэх хувь хүний хөгжлийн бодлогод анхаарч, багш нар шинэ

	<p>арга зүй, инноваци нэвтрүүлэхэд хамтран суралцах</p> <ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн дотоод, гадаадын сургалт, семинарт багш нарыг өөрийн санаачлага болон сургуулийн зүгээс оролцуулах ажлыг эрчимжүүлэх
Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт	<ul style="list-style-type: none"> • Санхүүжилт нэмэгдүүлэх бодлого боловсруулж, төлөвлөлт зохион байгуулах • Санхүүжилтийг нэмэгдүүлэхэд орон нутгийн боломж ашиглах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх • Гадаад болон дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, • Багш нарыг сургалт, судалгааны хэрэглэгдэхүүн гарын авлага, улмаар сурах бичиг боловсруулахыг дэмжих
Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем	<ul style="list-style-type: none"> • Сургалтын хөтөлбөрийг сурталчилгааны олон арга, хэлбэрүүд, эх сурвалжуудыг ашиглан бусад аймгуудад болон ОХУ, БНХАУ-д эрчимжүүлэх
Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> • Магистрын хөтөлбөрийн чанарын үнэлгээг тогтмолжуулах
Шалгуур	Шаардлага
2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй	<ul style="list-style-type: none"> • Магистрантын сургалтын хөтөлбөрийг иж бүрдэлээр боловсруулж, хэрэгжүүлэхийн зэрэгцээ стандарт, хөтөлбөр, судалгааны ажлыг үнэлдэг шалгуур, үзүүлэлт, өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээг цаашид хийх тал дээр анхаарах
2.4 Судалгааны ажил	<ul style="list-style-type: none"> • Судалгааны ажлыг Боловсрол судлалын мэргэжлийн профессор багш нарын баг удирдах, судалгааны ажлын чанарт анхаарах
3.3. Суралцагчийг дэмжих, зөвлөх үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тусгасан дүрэм, журмыг боловсруулах

4.4. Судалгаа ба хөгжил	<ul style="list-style-type: none"> • Багшийн хөдөлмөрийн үнэлгээг /үндсэн цалин, цагийн хөлс/ өсгөх • Багшийн эрдэм шинжилгээ, судалгаанд хэрэглэгдэх олон улсын чансаатай эрдэм шинжилгээний сэтгүүлийн өгүүллийн нөөцийг өсгөх
5.3. Төсөв, санхүүжилт	<ul style="list-style-type: none"> • Санхүүжилтийн талаар цаашид баримтлах бодлого боловсруулж, төлөвлөлт хийн хэрэгжүүлэх • Багш нарыг сургалт, судалгааны хэрэглэгдэхүүн /тестийн сан, дасгалын хураамж, даалгаврын дэвтэр, унших материалын эмхтгэл, хичээлийн агуулгын зурган танилцуулга зэргээс эхлэн/, гарын авлага, улмаар сурах бичиг боловсруулахыг дэмжихдээ олгогддог цагийн хэмжээг нэмэгдүүлэх, хэвлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шагнал, урамшуулал олгох, уралдаан зохион байгуулах, алдаршуулах, бүтээлийн үзэсгэлэнг тогтмолжуулах зэрэг тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлэх •

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил
1	Х. Нарантуяа	Гэрээт багш	БС-ын доктор	3 жил
2	С. Алтанцэцэг	Профессорын баг	БС-ын доктор	4 жил
3	Д. Алтантуяа	Багш	Хэл шинжлэлийн доктор	3 жил
4	Р. Жаргалтуяа	Ахисан түвшний хөтөлбөрийн албаны	Хэл шинжлэлийн доктор	3 жил

II. Магистрантуудын нэрс

№	Магистрантын нэрс	Сонгосон байдал
1	Д. Лхагвасүрэн	Дорнод, Хэрлэн сумын 18 дугаар цэцэрлэгийн арга зүйч
2	Г. Лхамсүрэн	Хэнтий, Хэрлэн сумын 4-р сургуулийн бага ангийн багш
3	Э. Алтанзул	Хэнтий, Хэрлэн сумын 1-р сургуулийн бага ангийн багш
4	Chen Hiang Hui	Хөлөн буйр сумын ажил мэргэжлийн дээд сургуулийн багш
5	Wen Xia	Хөлөн буйр дахь Чихангийн боловсролын багш
6	Hei Lingi	Хөлөн буйр сумын мэргэжлийн техникийн коллеж
7	Wu Yua Ga	Хөлөн буйр сумын Хайлаарын нэгдүгээр дунд сургуулийн багш
8	С. Дамдинцэцэг	Дорнод, Хэрлэн сумын 10-р цэцэрлэгийн багш
9	Б. Хөгжилцэцэг	Дорнод, Хэрлэн сумын 10-р цэцэрлэгийн багш
10	Ganlin	Хөлөн буйр сумын Зүүн барга хошууны амгалан 1 дүгээр дунд сургуулийн багш

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	WanG Shu En	Хөлөнбуйр дээд сургуулийн олон улсын боловсролын сургууль	гадаад харилцааны албаны дарга
2	Д. Гантуяа	Дорнод, Хэрлэн сумын ЕБ-ын 16 дугаар цэцэрлэг	эрхлэгч
3	Ш. Мандах	Дорнод ахлах сургууль	Захирал

4	Ж.Оюунжаргад	Сүхбаатар аймгийн Баруун –Урт сумын сургууль	Захирал
5	В. Алтансүвд	Дорнод аймаг, Хэрлэн сумын 11 дүгээр сургууль	Захирал
6	С.Мөнгөнтулга	Дорнод аймаг, Шинэ хөгжил цогцолбор ЕБ-ын сургууль	Сургалтын менежер
7	О. Бодьцэцэг	Дорнод аймаг, Гурван загал сумын ЕБ-ын сургууль	Захирал
8	Д. Отгонбаяр	Дорнод аймаг, Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэг	Эрхлэгч
9	Б. Энхзул	Дорнод аймаг, Хэрлэн сумын 18 дугаар цэцэрлэг	Эрхлэгч

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	С. Ганчимэг	2020.12	Сүхбаатар аймаг 4-р сургууль	Багш
2	Г. Мөнхцэцэг	2020.12	Сүхбаатар аймаг 4-р сургууль	Багш
3	Б. Насанжаргал	2022.12	Дорнод аймаг 1-р цэцэрлэг	Багш
4	М. Мөнхжаргал	2022.12	Дорнод аймаг 1-р цэцэрлэг	Багш
5	Xiimuge	2021.06	Хөлөн буйр сумын дунд сургууль	Багш
6	Anabada	2021.06	Хөлөн буйр сумын дунд сургууль	Багш
7	Nars	2021.06	Хөлөн буйр сумын дунд сургууль	Багш
8	Jing Jing	2020.06	Хөлөн буйр сумын дунд сургууль	Багш
9	Т. Эрдэнэтуяа	2021.06	Дорнод аймаг 8 –р цэцэрлэг	Багш
10	С. Мөнхтуяа	2021.06	Хэнтий аймаг 1 дүгээр цэцэрлэг	Багш
11	Л. Мөнхболор	2021.06	Хэнтий аймаг 1 дүгээр цэцэрлэг	Багш
12	Ч. Отгонжаргал	2021.006	Хэнтий аймаг 1 дүгээр цэцэрлэг	Багш
13	Н. Уранжаргал	2021.12	Дорнод аймаг 5-р сургууль	Багш

14	Н. Эрдэнэчимэг	2021.12	Дорнод аймаг 5-р сургууль	Багш
15	Б. Бямбажав	2020.12	Дорнод аймаг Шинэ хөгжил сургууль	Багш
16	Б. Сайнзаяа	2021.12	Хэнтий Батноров сумын сургууль	Багш
17	Э. Баярмаа	2021.12	Хэнтий Батноров сумын сургууль	Багш
18	Б. Баярцэцэг	2019.05	Дорнод ахлах сургууль	Захирал

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ДОРНОД АЙМАГ ДАХЬ СУРГУУЛЬ

Ялалт-1, 100, 4 дүгээр баг, Харлан сум, Дорнод аймаг, 21073

Утас/Факс: 7058-4667

Цахим шуудан: info@dornod.edu.mn

Цахим хуудас: dornod.edu.mn

2023-6-9 № 363
тапай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

МУИС-ийн Дорнод аймаг дахь сургуулийн "Боловсрол судлал"-ын магистрын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийж ажилласан шинжээчийн багаас ирүүлсэн тайлантай танилцлаа. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний баг тус шинжээчийн багийн дүгнэлт, зөвлөмжтэй санал нийлж байна.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Ч.УДВАЛНОРОВ